

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсвийн хөрөнгө оруулалтын
удирдлагын тухай анхдагч хуулийн
төслийн талаар

Нийгмийн шинжтэй буюу төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх зориулалттай бүтээн байгуулалтын төслийг төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлдэг. Төсвийн хөрөнгө оруулалтаар авто зам, эрчим хүч, инженерийн дэд бүтэц зэрэг нийтийн зориулалттай дэд бүтцийн бүтээн байгуулалтууд, мөн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, дотуур байр, музей, соёлын төв, захиргааны байр зэрэг төрийн үйлчилгээний барилга байгууламжуудыг барьж байгуулах төслийг хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлж, төрийн үйлчилгээг цаг алдалгүй иргэдэд хүргэхээс гадна эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн.

Монгол Улсад 2016-2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 16.5 их наяд, гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр 12.4 их наяд, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр 11.1 их наяд төгрөг буюу нийт 39.9 их наяд төгрөгийн эх үүсвэр тус тус хөрөнгө оруулалтаар батлагдаж, төслүүд хэрэгжсэн байна. Монгол Улсын хувьд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг улсын төсөв, гадаадын зээл, тусламж, орон нутгийн төсөв, төр, хувийн хэвшлийн түншлэл, орон нутгийн хөгжлийн сан, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө, хөгжлийн сан болон санхүүгийн бусад эх үүсвэрүүд бүрдүүлдэг.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын асуудлыг зохицуулсан бие даасан хууль байхгүй бөгөөд суурь харилцааг Төсвийн тухай хуульд голчлон зохицуулж, хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, гүйцэтгэл, хяналт, тайлагналттай холбоотой зарчмын шинжтэй чухал асуудлууд холбогдох бусад хууль тогтоомж болон Засгийн газар, Сангийн сайдын баталсан журам, аргачлалуудаар зохицуулагдаж байна. Эдгээр хууль тогтоомж хоорондын уялдаа холбоо сул, нэгдсэн зохицуулалт хангалтгүй, хяналт, тайлагналтын харилцааг журмаар зохицуулдаг нь хариуцлагын тогтолцоог сулруулж, эдийн засгийн үр ашигт сөргөөр нөлөөлөх нөхцөл болдог.

Практикт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх гурван төсөл тутмын нэгэд нь нэмэлт санхүүжилт үүсэж, нэг нь төлөвлөсөн хугацаанаас нэгээс дээш жилээр хойшилж ашиглалтад орж байна. Тухайлбал, зөвхөн сүүлийн 2 жил буюу 2023 онд барилгын материалын үнийн өсөлтөд 303.4 тэрбум төгрөг, 2024 онд аудитын дүгнэлтээр 660.6 тэрбум төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосон байдаг. Улмаар төсөвт нэмэлт ачаалал үүсгэж, барилга байгууламж, дэд бүтэц хугацаандаа ашиглалтад ороогүйн улмаас боловсрол, эрүүл мэнд зэрэг нийгмийн үйлчилгээний хүртээмж саарч, төсвийн хөрөнгө оруулалтын өгөөж буурах сөрөг үр дагаварт хүргэж байна.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийн зориулалт тодорхой бус, төслийн ангилал, төрөл байхгүй, төслийн бэлтгэл ажилтай холбоотой нэгдсэн ойлголт, удирдлага, зохицуулалт хангалтгүйн улмаас жил бүрийн төсвийн төсөлд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр ирүүлсэн нийт төслийн саналын дунджаар 15-20 хувь нь төсөвт тусгагдаж, дийлэнх буюу 80-85 хувь нь

шийдвэрлэгдэхгүй үлдэж байна. Төслийн хэмжээ болон салбарын онцлогтой уялдуулан нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох, түүнд үндэслэн үнэлгээний шалгуур үзүүлэлтээр эрэмбэлэх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлдэг эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгцээ, шаардлагагүй, үр ашиггүй төсөл хэрэгжих буюу нэмэлт санхүүжилт гарахаас урьдчилан сэргийлсэн зохицуулалтыг бий болгох нь зүйтэй байна.

Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлдэг гадаадын зээл, тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн бодлого, зохицуулалтыг сайжруулах, төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд эдгээрийг давхардалгүй, харилцан уялдаатай, үр ашигтай, оновчтой төлөвлөж, хуваарилах, ач холбогдлын эрэмбэ, үнэлгээнд үндэслэдэг байх, шаардлагагүй тохиолдолд зээлийн хөрөнгө оруулалт авахгүй байх, төсөл, арга хэмжээг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, санхүүжилт, зарцуулалт, бүртгэл, тайлагналт, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай болно.

Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.2.2-т “Эдийн засгийн нийт нөөц, улирлын онцлогтой нийцүүлэн төсвийн хөрөнгө оруулалтын эрэмбэ, дарааллыг оновчилж, нийгэм, эдийн засгийн салбарт оролцох хүрээ, хязгаарыг хуулиар тогтоож, ... хиймэл оюун ухааныг ашиглана” гэж, 3.2.2.14-т “Төсвийн хөрөнгө оруулалтыг их өгөгдөлд суурилан төлөвлөнө” гэж, Ерөнхий сайдын “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 2025 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 02 тоот албан даалгаврын 3.5-д “Төсвийн хөрөнгө оруулалт, томоохон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтийг шийдвэрлэх чиглэлээр хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хуулийн төсөл боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Сангийн сайдад даалгах” гэж тус тус заасан.

Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16¹.5.4-т¹ заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай багц хуулийн төсөлд өгсөн дүгнэлтдээ “Хөрөнгө оруулалтын төслийг сонгох, эрэмбэлэх, хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай” гэж, “Хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц хууль эрх зүйн орчин хэрэгтэй” гэж онцлон тэмдэглэсэн бөгөөд энэ хүрээнд “... хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулан гаргах шаардлагатай” гэж, мөн “Төсвийн хөрөнгө оруулалтыг сонгох, эрэмбэлэх, үр ашгийг тооцоход журмын зохицуулалт хангалтгүй бөгөөд хөрөнгө оруулалтын эрх зүйн цогц орчин бий болгохын тулд бусад орнуудын сайн туршлагын дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинээр боловсруулах шаардлагатай” болохыг чухалчлан зөвлөсөн. Түүнчлэн, Дэлхийн банк Олон Улсын Валютын Сан болон Үндэсний аудитын газрын тайлан, дүгнэлт, зөвлөмжид төсвийн хөрөнгө оруулалтын төслийг амжилттай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай болохыг зөвлөсөн байдаг.

¹ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 16¹.5.4. Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу төсөвтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийн улсын төсөвт нөлөөлөл, ачаалал үзүүлэх эсэх талаар шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргаж танилцуулах;

Дээр дурдсаны дагуу төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд судалгаа, шинжилгээг хийх, холбогдох хуулийн төслийг боловсруулах чиг үүрэг бүхий үндсэн ажлын хэсгийг Сангийн сайдын 2024 оны 204 тоот тушаалаар, дэд ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/243 тоот тушаалаар тус тус байгуулсан.

Ажлын хэсгүүдээс төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал, түүнийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу анхдагч хуулийн хэрэгцээ, шаардлагын талаарх урьдчилсан тандан судалгаа, олон улсын харьцуулсан судалгаа, шүүхийн практикийн тойм судалгаа зэрэг суурь судалгаануудыг хийж гүйцэтгэсэн. Тандан судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтын шинэчлэлийг эрчимжүүлж, хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд **Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг** боловсруулж, батлуулах шаардлагатай болох нь тогтоогдсон.

Тандан судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтын харилцаанд хууль, эрх зүйн нэгдмэл орчин байхгүй, тодорхой бус, зарим асуудлыг нэгдсэн байдлаар бүрэн зохицуулаагүй, Төсвийн тухай хуулиар төсөл сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийх, үр дүнг тооцох, тайлагнах, өмч ашиглалттай холбоотой асуудлыг бүрэн зохицуулаагүй, зөвхөн төслийн төлөвлөлттэй холбоотой харилцааг зохицуулдаг, зарим харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулдаг, төсөл, арга хэмжээг сонгон шалгаруулах мэдээлэл олон нийтэд нээлттэй бус, олон нийтийн оролцоо хангалтгүй, төслийн хөндлөнгийн үнэлгээ, хэрэгжилтэд тавих хяналтын тогтолцоо сул, эрсдэлийн удирдлагын менежмент дутмаг болох нь мөн тогтоогдсон.

Мөн, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын зарим харилцааг хуулиар, зарим харилцааг журмаар зохицуулдаг бөгөөд зарим асуудлууд огт зохицуулалтгүй буюу хууль зүйн хийдэл үүссэн. Тухайлбал:

- улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг бэлтгэх асуудлыг Төсвийн тухай хуульд тусгасан хэдий ч бусад хөрөнгө оруулалтын төслүүдийн талаар хуульд тодорхой тусгаагүй;
- мега төсөл, ногоон хөрөнгө оруулалт, их өгөгдөлд суурилан төлөвлөлтийг хийх талаарх зохицуулалт байхгүй;
- төсөлд тохируулга хийх болон төсөлд (бие даасан) хяналт тавих, төслийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг хуулиар зохицуулаагүй;
- төсөл хэрэгжүүлэх, төслийн тогтвортой үйл ажиллагааг хангахтай холбогдсон харилцааг хуульд тодорхой авч үзээгүй гэх мэт.

Иймд, хууль санаачлагчаас төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлдэг улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл, тусламж, орон нутгийн хөгжлийн сангийн бодлого, зохицуулалтыг сайжруулах, төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд эдгээрийг давхардалгүй, харилцан уялдаатай, үр ашигтай, оновчтой төлөвлөж, хуваарилах, ач холбогдлын эрэмбэ, үнэлгээнд үндэслэдэг байх, шаардлагагүй тохиолдолд зээлийн хөрөнгө оруулалт авахгүй байх, төсөл, арга хэмжээг үр ашигтай, үр дүнтэй хэрэгжүүлэхэд төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллагууд болон бусад оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, санхүүжилт, зарцуулалт, бүртгэл, тайлагналт, ил тод байдлыг сайжруулахад чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилго тавьж ажилласан.

Тандан судалгаанд үндэслэн хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулахын зэрэгцээ Сангийн яамнаас санаачлан дангаар болон бусад төрийн захиргааны төв байгууллагатай хамтран 2025 оны 2 дугаар сараас эхлэн цуврал хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтад оролцогч талуудын саналыг хуулийн төсөлд тусган ажиллаж байна.

Олон улсын харьцуулсан судалгаагаар төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тогтолцоог боловсронгуй болгосон улс орнууд хөрөнгө оруулалтын тодорхойлолт, хамрах хүрээ, төслийн ангиллыг нарийвчлан тогтоож, төлөвлөлт, үнэлгээ, санхүүжилт, хяналтын асуудлаар нэгдсэн зохицуулалтыг эрх зүйн түвшинд бүрдүүлснээр хөрөнгө оруулалтын үр ашиг, өгөөжийг бодитоор нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, БНСУ, ИБУИНХУ зэрэг улс биет хөрөнгө оруулалтаас гадна технологи, судалгаа, хөгжүүлэлт зэрэг биет бус хөрөнгө оруулалтыг төсвийн хөрөнгө оруулалтын тогтолцоонд багтааж, төсөл бүрд өртөг, салбар, ач холбогдлоос хамаарсан ангилал тогтоож, тухайн ангилалд нийцсэн шаардлага, шалгуурыг баримталдаг бол Казахстан, Чили зэрэг улсад төсөлд тавигдах шаардлагыг тодорхой тогтоож, үнэлгээний нөхцөлийг нэгдсэн байдлаар тогтоодог бөгөөд зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх, цахим системд ил тод байдлыг хангах замаар хөрөнгө оруулалтын төслүүдийн чанар, үр өгөөжийг дээшлүүлдэг байна. Монгол Улсад мөн төсвийн хөрөнгө оруулалтын процессын бүх үе шатанд ил тод, харилцан уялдаа бүхий нэгдсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зүйтэй бөгөөд хуулийн төслийг боловсруулахдаа олон улсын сайн туршлага, судалгааны дүнг харгалзан үзсэн болно.

Анхдагч хуулийн төслийн талаар

Хууль тогтоомжийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төслийг 8 бүлэг 52 зүйлтэй боловсруулсан бөгөөд хуулийн зорилго нь хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд нийгэм, эдийн засгийн дэд бүтцийг бүрдүүлэхэд төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалтыг ил тод, үр ашигтай хэрэгжүүлэхтэй холбогдуулан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын эрх зүйн нэгдмэл орчныг бүрдүүлэхэд оршино.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөлд дараах зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

1. Хуулийн хамрах хүрээг тодорхойлж, төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, төслийн төлөвлөлт, төслийн хэрэгжилт, төслийн санхүүжилт, тайлагналт, хяналт, магадлалын дүгнэлт, эдийн засгийн үр ашиг, үр өгөөж, ТЭЗҮ зэрэг 31 орчим нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж, , төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага /цаашид "ТХОУ" гэх/-д баримтлах нийцлийн, үр ашигтай байх, эрэмбийн, ил тод байдлын, хяналтын, оновчтой хөрөнгө оруулалтын зэрэг 10 зарчмыг тодорхойлов. Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтын төслийг төсөвт өртөг болон хэрэгжүүлэх хугацаанаас хамааран 1-5 түвшинд ангилж, төслийн төрөл, ТХОУ-ын цаглавар болон хориглох зүйл зэргийг тусгалаа.
2. Засгийн газар, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн эрхэлсэн Засгийн

газрын гишүүн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга болон захиалагч зэрэг ТХОУ-д оролцогч этгээдүүдийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаарх бүрэн эрх, чиг үүргийг хуулийн төсөлд тусган ажиллалаа.

3. ТХОУ-ын хамгийн чухал үе шат бол төлөвлөлт болон бэлтгэл үе шат байдаг. Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт нийтэд нь төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үе шатыг зохицуулсан бөгөөд төсвийн хөрөнгө оруулалтын бодлого, тэргүүлэх салбарыг тодорхойлж, хөрөнгийн эх үүсвэрийн зориулалтын суурь зохицуулалт, төлөвлөлтийн үйл ажиллагаа буюу төслийг төлөвлөх, бэлтгэх үе шат, төслүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагын талаар зохицуулсан. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд их өгөгдөл, хиймэл оюун ухаан, цахим системийг ашиглах талаар мөн авч үзсэн.
4. Хуулийн төслийг боловсруулахдаа ТХОУ-ыг хэрэгжүүлэх оновчтой 5 үе шат буюу процессын дарааллыг хадгалах зарчмыг баримталсан бөгөөд төслийн 4 дүгээр бүлэгт төслийн төлөвлөлт, бэлтгэл ажиллагааг хангасан, төсөвт тусгагдан батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналтын асуудлыг хуульчлан зохицуулсан. Тодруулбал, багц хуваарилах болон эрх шилжүүлэх асуудал, тендер шалгаруулалт, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах буюу гэрээний удирдлагын талаар, үүнд тендерийн уламжлалт гэрээнээс гадна олон улсын жишиг гэрээг /ФИДИК/ байгуулах боломж, хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилт, гүйцэтгэл, гүйцэтгэлийн санхүүжилт, төслийн санхүүжих дүнд хийх хөрөнгийн зохицуулалтын талаар тусгалаа. Үүнээс гадна, төслийн гүйцэтгэлд тавих хяналт, захиалагчийн техникийн болон зохиогчийн хяналтын тухай болон төслийн хэрэгжилтийн тайлагналт, үр дүнгийн зохицуулалтыг хуульчилсан.
5. ТХОУ-ын шуурхай, ил тод, нээлттэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх, бүх үе шатны ажлыг техникийн хувьд хөнгөвчлөх, цахим хөгжлийн дэвшлийг нэвтрүүлэх шийдлийг Сангийн яамны зүгээс 2018 оноос хойш үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтын PIMIS нэгдсэн цахим системийн удирдлагыг амжилттай хэрэгжүүлж байгаа юм. Тиймээс ч энэхүү хуулийн төслийн 5 дугаар бүлэгт ТХОУ-ын ил тод, нээлттэй байдал, цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх асуудал, төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, удирдах талаар, мөн олон нийтийн оролцоо, ил тод байдлыг хангах талаар тусгасан.
6. Хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн удирдлага, ашиглалт, түүний үр өгөөжийг тооцох талаар авч үзсэн бөгөөд энэ нь хуулийн төслийн шинэлэг зохицуулалт юм. Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг тогтмол, үр ашигтай хэрэгжүүлэх нь шаардлагагүй шинэ төсөл санхүүжүүлэх, төсвийн эрсдэлээс сэргийлэх ач холбогдолтой. Иймд, хуулийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон өмч, хөрөнгийн хөрөнгийг

удирдлагыг хэрэгжүүлэх, нийтийн буюу төрийн болон орон нутгийн өмчид бүртгэх, өмч, хөрөнгийн ашиглалт, сайжруулалт, тэдгээрийн үр өгөөжийг тооцож, хөрөнгийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг зохицуулсан.

7. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртгөөс Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль зэрэг холбогдох хуульд заасны дагуу норм, нормативын санд тодорхой дүнгээр суутган төвлөрүүлдэг. Тандан судалгаагаар эдгээр норм, нормативын сангийн удирдлага сул, норм, нормативын баримт бичгийн шинэчлэл хийдэггүй, сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулдаг, хариуцлагын тогтолцоо хангалтгүй болох нь тогтоогдсон. Иймээс, хуулийн төсөлд төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдаж буйг өөрчилж, норм, нормативын сангийн удирдлага, менежментийг шинэчлэх зорилгоор ТХОУ-ын сан буюу норм, нормативын сангийн удирдлага, сангийн эх үүсвэр болон зарцуулалт, тайлагналт, ил тод байдлын талаарх зохицуулалтыг тусгалаа. Үүнээс гадна, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн гүйцэтгэгч этгээдийг тодорхой шалгуурын дагуу үнэлж, төсөл хэрэгжүүлэхэд үнэлгээг тооцох асуудлыг авч үзэв.
8. Хуулийн төслийн төгсгөлийн бүлэгт төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын явцад үүссэн маргааныг шийдвэрлэх, хохирол, гэм хорыг нөхөн төлүүлэх, хууль тогтоомж, гэрээний үүргийн зөрчилд хариуцлага хүлээлгэх үндэслэл, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага болон хууль хүчин төгөлдөр болох талаар тусгалаа.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай анхдагч хуулийн төсөл батлагдсанаар ТХОУ-ын оновчтой, зөв бодлогыг тодорхойлж, улсын болон бүс нутгийн хөгжилд зориулсан төсөл, хөтөлбөрүүдийг үр дүнтэй, амжилттай хэрэгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх, дэд бүтцийн болон нийгмийн хөгжлийг эрчимжүүлж, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад төсвийн хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн нэгдмэл, цогц, таатай орчныг бүрдүүлэх томоохон ач холбогдолтой юм. Түүнчлэн, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын чухал харилцааг захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгааг цэгцэлж, журмаар бус Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулах боломж бүрдэнэ.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хууль санаачлагчаас хуулийн төслийн бүрдүүлбэрийг хангахын зэрэгцээ олон улсын байгууллага, төрийн байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагчид, төсвийн хөрөнгө оруулалтад оролцогч талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг, уулзалтуудыг зохион байгуулж, тэдгээрийн саналуудыг хуулийн төсөлд тусган ажиллаж байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт цахим хуудсанд байршуулж, холбогдох саналыг хуулийн төсөлд тусгахаар ажиллаж байна.

---o0o---